



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/109

Улаанбаатар хот

Барилга угсралтын ажилд техник
хяналт тавих тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2009 оны Барилга захиалагчийн дүрэм батлах тухай 73 дугаар тогтоолын хавсралтын 3.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн Гадаадын зээл тусламжаар хэрэгжих төсөл хөтөлбөр болон Улаанбаатар хотод хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын барилга угсралтын техник хяналт тавих эрхийг Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраар, орон нутагт хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын барилга угсралтын техник хяналт тавих эрхийг Барилга хөгжлийн төв болон орон нутгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраар хийлгэж, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар, Барилга хөгжлийн төв, тухайн аймаг дахь Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай техник хяналт тавих гэрээ байгуулахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д зөвшөөрсүгэй.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080416